

□
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар А/543

Улаанбаатар хот

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус бохирдуулах аюултай бодисын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Ус бохирдуулсны төлбөр тооцоход ус бохирдуулах аюултай бодисын жагсаалтыг мөрдүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Ш.Мягмар/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н.Цагаанхүү/-т тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Жагсаалт батлах тухай" Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-294 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Н.Цэрэнбат